

## ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Эдийн Засгийн Сургуулиас эрхлэн гаргадаг “ЭДИЙН ЗАСАГ: онол, практик” сэтгүүлийн ээлжит дугаарыг Та бүхэндээ толилуулж байна.

Сэтгүүлийн энэ дугаарт макро эдийн засаг, банк, санхүү, менежмент болон мэдээллийн технологийн салбарын сонирхол татсан, шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай асуудлуудыг зүй ёсоор хөндсөн өгүүллүүд нийтлэгдэж байна. Тухайлбал, академич П.Лувсандорж “Шилжилтийн үе хөгжлийн үетэй нэгдэв” өгүүлэлдээ “...хөгжлийн бэрхшээл, өвөрмөц асуудлууд гараад байгаагийн учир шалтгаан нь хөгжиж буй эдийн засагт оршино” хэмээгээд, шилжилтийн үе хөгжлийн үетэй нэгдэн нийлснийг харуулах сонирхолтой баримтуудыг дурдсан бол Доктор, профессор Б.Батмөнх “Монгол Улсад зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчмууд хэрэгжиж байгаа байдал: сорилт, бэрхшээл” өгүүлэлдээ ХБНГУ-ын хөгжлийн загвар болох нийгмийн баримжаатай зах зээлийн үндсэн зарчмууд тэдгээрээс Монгол Улсын ирээдүйн хөгжлийн загварт тусгаж болох асуудлыг хөндсөн байна. Ийнхүү энэ дугаарт нийтлэгдэж байгаа өгүүлэл бүр тухайн сэдвийнхээ хүрээнд онол, практикийн ач холбогдол бүхий асуудлуудыг тусгагдсан харуулснаараа онцлог юм.

Сэтгүүлд нийтлэгдэж байгаа өгүүллүүдийн талаар болон сэтгүүлийн чанар чанасааг цаашид сайжруулах талаар өөрсдийн санал, зөвлөмжөө ирүүлнэ үү. Уншигч таны санал, зөвлөмж, шинэлэг санааг хүлээж авахад таатай байх болно.

Сэтгүүлийн редакц

**Академич П.Лувсандорж**  
**Профессор Б.Сувд**

## Зохиогчид

1. **П.Лувсандорж.** Монгол Улсын ШУ-ны Гавъяат, Академийн гишүүн (Академич) МУИС-ийн ЭЗХ-ийн захирал, Эдийн засгийн ухааны доктор, профессор Судалгааны чиглэл: “Хөгжлийн эдийн засаг”, “Шилжилтийн эдийн засаг” Сүүлийн үеийн бүтээл “Шинэ хуучин эдийн засагч шинжээчдийн үе” ЭЗОП сэтгүүл.2010.№339/25.
2. **Б.Батмөнх.** Доктор, дэд профессор МУИС-ийн ЭЗС-ийн Статистикийн тэнхим. Судалгааны чиглэл: Макро болон шилжилтийн эдийн засаг: Бүтээл.”Монгол улс: Шилжилтийн эдийн засгаас сонгуулийн эдийн засагт” ЭЗОнол практик сэтгүүл 2011/351/27.29
3. **Ч.Энхбаяр.** Доктор, профессор МУИС-ийн ЭЗС-ийн санхүүгийн тэнхимийн эрхлэгч.  
**Г.Пүрэвсүрэн.** МУИС-ийн докторант МУИС-ийн Завхан дахь салбар сургуулийн санхүүгийн тэнхимийн багш.
4. **Д.Энхтүвшин.** МУИС-ийн ЭЗС-ийн санхүүгийн тэнхимийн багш Судалгааны чиглэл : Санхүүгийн загварчлал.
5. **Л.Мөнх-Очир.** Доктор, профессор МУИС-ЭЗС-ийн НББ-ын тэнхимийн багш .Судалгааны чиглэл. “Аудитын удирдлага, үнэлгээ хөрөнгө оруулалтын төслийн шинжилгээ”  
**Ж.Ариунболд.** МУИС-ийн ЭЗС-ийн докторант. Судалгааны чиглэл: “Төрийн өмчит үйлдвэрийн газруудын балансад шинжилгээ хийх арга зүй”
6. **Д.Авирмэд.** Дэд профессор МУИС-ЭЗС-ийн НББ-ын тэнхимийн багш Судалгааны чиглэл. “Удирдлагын тогтолцооны арга зүйн асуудал”
7. **Ч.Ундрам, Б.Болор, Б.Энхмаа, Ж.Сарантуяа, Ш.Цэрэндулам.** МУИС-ийн ЭЗС-ийн менежментийн тэнхимийн багш нар.
8. **Н.Лизунов.** МУИС-ийн дэд профессор, Судалгааны ажлын чиглэл нь үйлдвэрлэлийн менежмент. Бүтээл “Менежментийн нь өрсөлдөх чадварыг хангах хэрэгсэл мөн. ЭЗОнол практик сэтгүүл 2011/351/27.
9. **Д.Чимгээ.** Профессор. МУИС-ийн ЭЗС-ийн ЭЗМЗ-ын тэнхимийн багш Судалгааны чиглэл: Удирдлагын мэдээллийн систем, Электрон засгийн газар, Төрийн удирдлагын мэдээллийн систем, электрон арилжаа, электрон бизнес, мэдээлэл харилцаа холбооны технологи, менежмент, маркетинг, нягтлан бодох бүртгэл, аудитын мэдээллийн систем, электрон сургалт.
10. **Я.Отгонсүрэн.** Доктор(PhD) ЭЗС-ийн Маркетинг, Олон улсын худалдааны тэнхимийн эрхлэгч. Сүүлийн бүтээл: “Борлуулалтын ажлын зохион байгуулалтын зарим асуудал”. ЭЗОП сэтгүүл 2010/329/24.
11. **М.Булгантамир.** МҮДС-ийн багш докторант.